



АУДИТЫН ТАЙЛАН

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2023/09/ НА-СА-ТТЗ

	Санхүү-нийцлийн хэлтсийн дарга, аудитын менежер: З.Мөнхбаяр	Утас: 11327734 Цахим хаяг: munkhbayarz@audit.gov.mn
	Аудитын менежер: Д.Отгонбаяр	Утас: 11315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn
Цахим хуудас: www.open.audit.mn	Ахлах аудитор: Г.Долгорсүрэн	Утас: 11325093 Цахим хаяг: dolgorsureng@audit.gov.mn
Улаанбаатар 2023 он	Аудитор: Н.Бадамхатан	Утас: 11325093 Цахим хаяг: badamkhatann@audit.gov.mn
	Аудитор: Ш.Мөнхжаргал	Утас: 11325093 Цахим хаяг: munkhjargalsh@audit.gov.mn
	Аудитор: З.Мөнхзаяа	Утас: 11325093 Цахим хаяг: munkhzayaz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэгдсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	19
4. АУДИТЫН ТАЙЛАН	23
4.1 Ерөнхий зүйл.....	23
4.2 Материаллаг байдал	23
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	23
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	24
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	24
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	25
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	26
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	33

Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ОНӨУҮГ	Орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газар
ААН	Аж ахуйн нэгж
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЖДҮДТ	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв
ГБХЗХХ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс
ХААА	Худалдан авах ажиллагааны алба

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2023.03.24

№

852

танай

-ны №

-т

НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА
Н.БАТСҮМБЭРЭЛ ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиуд шинээр батлагдаж, мөрдөж ажилласан.

Дүүргийн удирдлага нь санхүүгийн нэгтгэсэн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус дүүргийн талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул дүүргийн тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

D:\Desktop\0023\Word\Ресон Баттөр\2023.03.25\CHD\2DTG.docx

0020-1626

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Дүүргийн удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 6 агуулга, 84 зорилтын хүрээнд 176 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.58 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэх толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		39,692,515.6	32,025,354.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	20,808,124.1	19,388,390.5
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	362,028.0	279,700.0
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	75,414.4	638,558.8
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	8,368,880.5	2,397,392.2
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	10,078,068.5	9,321,313.3
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		171,271,995.4	91,144,034.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	171,271,995.4	91,144,034.4
39200	Биет хөрөнгө		124,746,871.9	50,228,195.8
39300	Биет бус хөрөнгө	13	46,525,123.5	40,915,838.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		210,964,511.0	123,169,389.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		2,068,989.7	663,871.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	2,068,989.7	663,871.5
41300	Өглөг	17а, 17б	2,068,989.7	663,871.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		208,895,521.3	122,505,517.6
51	Засгийн газрын хувь оролцоо		208,895,521.3	122,505,517.6
51100	Засгийн газрын оруулсан капитал		84,623,141.7	62,267,492.3
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		84,623,141.7	62,267,492.3
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		40,000.0	40,000.0
51200	Хуримтлагдсан үр дүн		85,440,450.3	48,764,318.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		38,791,929.3	11,433,706.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		210,964,511.0	123,169,389.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		150,442,228.6	162,625,382.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО		87,977,619.3	157,874,123.9
110	Орлогын албан татвар		33,931,151.4	117,787,303.3
1100	Хувь хүний орлогын албан татвар		33,931,151.4	117,787,303.3
113	Хөрөнгийн албан татвар		42,697.9	4,279,843.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж		54,003,770.1	35,806,977.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	60,140,341.6	3,872,258.4
120	Нийтлэг татварын бус орлого		14,086,142.4	2,662,536.4
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		46,054,199.2	1,209,722.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,324,267.7	879,000.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	123,774,715.9	152,660,437.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ		123,774,715.9	152,660,437.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		87,310,891.8	49,903,339.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		37,470,917.4	6,671,162.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		4,954,573.7	859,482.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		4,329,012.1	5,797,601.5
2104	Хангамж, бараа материалын зардал		12,195,462.2	13,068,690.6
2105	Нормативт зардал		671,145.7	41,315.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,134,675.4	1,564,133.3
2107	Томилолт, зочны зардал		-	330,789.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		10,367,069.8	10,968,495.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		16,188,035.5	10,601,668.5
212	ТАТААС		1,713,841.7	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		34,749,982.4	102,757,097.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		26,667,512.8	9,964,944.8
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		-	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		7,116,246.2	95,704,418.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		19,551,266.6	(85,739,473.7)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	188,062,335.1	-	188,062,335.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,283,675.9	-	1,283,675.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	189,346,010.9	-	189,346,010.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(1,756.2)	-	(1,756.2)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	19,551,266.6	-	19,551,266.6
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208,895,521.3	-	208,895,521.3
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	208,895,521.3	-	208,895,521.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(640,498.9)	-	(640,498.9)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	208,255,022.3	-	208,255,022.3
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(10,031.0)	-	(10,031.0)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	(85,739,473.7)	-	(85,739,473.7)
20	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,505,517.6	-	122,505,517.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		138,711,810.8	161,565,122.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО		87,977,619.3	157,874,123.9
110	Орлогын албан татвар		33,931,151.4	117,787,303.3
1100	Хувь хүний орлогын албан татвар		33,931,151.4	117,787,303.3
113	Хөрөнгийн албан татвар		42,697.9	4,279,843.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж		54,003,770.1	35,806,977.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		53,421,410.2	34,134,475.6
1181	Газрын төлбөр		582,359.8	1,672,502.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		48,423,604.5	2,738,439.5
120	Нийтлэг татварын бус орлого		2,369,405.3	1,528,717.4
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		46,054,199.2	1,209,722.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,310,587.0	952,559.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		112,766,338.6	146,732,746.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ		112,766,338.6	146,732,746.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		76,212,513.0	42,610,158.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		37,471,474.5	6,665,239.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		4,938,409.7	861,332.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		4,325,418.3	5,797,676.5
2104	Хангамж, бараа материалын зардал		11,871,217.9	12,763,711.1
2105	Нормативт зардал		830,893.5	41,806.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,057,599.5	1,846,787.9
2107	Томилолт, зочны зардал		-	367,513.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		9,811,725.0	11,066,219.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		5,905,774.6	3,199,870.7
212	ТАТААС		1,713,841.7	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		34,839,983.9	104,122,588.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		25,945,472.2	14,832,376.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		9,505,876.2	16,252,110.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		9,505,876.2	16,252,110.2
2200	Дотоод эх үүсвэрээр		9,505,876.2	16,252,110.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		(9,505,876.2)	(16,252,110.2)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		16,439,595.9	(1,419,733.6)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,368,528.2	20,808,124.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		20,808,124.1	19,388,390.5

2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	177,311,367.4	161,869,410.6	15,441,956.8	91.3
УРСГАЛ ЗАРДАЛ	149,530,236.0	146,592,539.1	2,937,696.9	98.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,958,571.1	43,128,967.0	1,829,604.1	95.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,024,245.9	6,665,239.7	359,006.2	94.9
Үндсэн цалин	4,373,961.0	4,225,680.6	148,280.4	96.6
Нэмэгдэл	872,069.2	852,907.7	19,161.5	97.8
Унаа хоолны хөнгөлөлт	1,167,321.9	1,048,524.1	118,797.8	89.8
Урамшуулал	578,368.2	518,734.3	59,633.9	89.7
Гэрээт ажлын хөлс	32,525.6	19,393.0	13,132.6	59.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	940,403.4	861,332.3	79,071.1	91.6
Тэтгэврийн даатгал	652,928.4	593,761.3	59,167.1	90.9
Тэтгэмжийн даатгал	73,181.0	68,276.2	4,904.8	93.3
ҮОМШӨ-ний даатгал	58,013.0	53,521.9	4,491.1	92.3
Ажилгүйдлийн даатгал	14,199.8	13,076.5	1,123.3	92.1
Эрүүл мэндийн даатгал	142,081.2	132,696.3	9,384.9	93.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,606,257.9	5,797,676.5	808,581.4	87.8
Гэрэл, цахилгаан	2,522,305.0	2,049,302.8	473,002.2	81.2
Түлш, халаалт	2,799,862.6	2,635,169.1	164,693.5	94.1
Цэвэр, бохир ус	1,235,502.4	1,077,016.7	158,485.7	87.2
Байрны түрээс	48,587.9	36,187.9	12,400.0	74.5
Хангамж, бараа материалын зардал	12,794,054.0	12,764,509.1	29,544.9	99.8
Бичиг хэрэг	114,584.1	112,090.4	2,493.7	97.8
Тээвэр, шатахуун	157,547.9	147,264.4	10,283.5	93.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	127,698.6	117,924.0	9,774.6	92.3
Ном, хэвлэл	2,500.0	2,499.8	0.3	100.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,049,313.1	12,046,593.3	2,719.8	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	342,410.3	338,137.3	4,273.0	98.8
Нормативт зардал	56,212.2	40,806.9	15,405.3	72.6
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,896.2	5,887.4	8.8	99.9
Хоол, хүнс	41,616.0	26,219.5	15,396.5	63.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,700.0	8,700.0	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	2,487,917.4	2,377,405.0	110,512.4	95.6
Багаж, техник, хэрэгсэл	463,892.7	427,312.0	36,580.7	92.1
Тавилга	137,200.0	81,281.0	55,919.0	59.2
Урсгал засвар	1,886,824.7	1,868,812.0	18,012.7	99.0
Томилолт, зочны зардал	437,000.0	367,513.5	69,486.5	84.1
Гадаад албан томилолт	360,000.0	304,882.5	55,117.5	84.7
Дотоод албан томилолт	25,000.0	15,565.5	9,434.5	62.3
Зочин төлөөлөгч хүлээн авах	52,000.0	47,065.5	4,934.5	90.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,139,014.4	11,047,633.4	91,381.0	99.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,695,675.9	10,627,627.4	68,048.5	99.4
Даатгалын үйлчилгээ	1,634.5	1,111.9	522.6	68.0
Тээврийн хэрэгслийн татвар	3,341.0	964.1	2,376.9	28.9
Тээврийн хэрэгслийн оношилгоо	614.0	143.0	471.0	23.3
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	50,495.5	38,797.4	11,698.1	76.8

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Газрын төлбөр	387,253.5	378,989.7	8,263.8	97.9
Бараа үйлчилгээний бусад зардал	3,473,465.9	3,206,850.7	266,615.2	92.3
Бараа үйлчилгээний бусад зардал	3,423,695.9	3,160,764.9	262,931.0	92.3
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	49,770.0	46,085.8	3,684.2	92.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	104,571,664.9	103,463,572.1	1,108,092.8	98.9
Засгийн газрын урсгал шилжүүлэг	103,086,813.0	102,380,994.8	705,818.2	99.3
Засгийн газрын дотоод шилжүүлэг	103,086,813.0	102,380,994.8	705,818.2	99.3
Бусад урсгал шилжүүлэг	1,484,851.9	1,082,577.3	402,274.6	72.9
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	500,000.0	204,400.0	295,600.0	40.9
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	300,000.0	210,000.0	90,000.0	70.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,200.0	11,139.5	60.5	99.5
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,537.2	31,536.3	0.9	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	642,114.7	625,501.5	16,613.2	97.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,781,131.4	15,276,871.5	12,504,259.9	55.0
Барилга байгууламж	2,800,000.0	2,335,124.6	464,875.4	83.4
Бусад хөрөнгө	24,981,131.4	12,941,746.9	12,039,384.5	51.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	177,311,367.4	161,861,802.2	15,449,565.2	91.3
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,209,722.1	1,283,281.4	(73,559.3)	106.1
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	1,209,722.1	1,283,281.4	(73,559.3)	106.1
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	155,426,073.0	160,378,443.4	(4,952,370.4)	103.2
Орон нутгийн төсвөөс	155,426,073.0	160,378,443.4	(4,952,370.4)	103.2
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	20,675,572.3	200,077.4	20,475,494.9	1.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	147,131.1	165,031.5	(17,900.4)	112.2
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,724.5	35,046.0	(29,321.5)	612.2
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	20,522,716.7	-	20,522,716.7	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	596,295.6	(596,295.6)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	588,288.7	(588,288.7)	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2,389	777	1,612	32.5
БАЙГУУЛЛАГЫН ТОО	69	69	-	100.0
Төсвийн байгууллага	69	69	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	357	346	11	96.9
Удирдах ажилтан	15	14	1	93.3
Гүйцэтгэх ажилтан	250	239	19	92.4
Үйлчлэх ажилтан	86	96	(10)	111.6
Гэрээт ажилтан	6	5	1	83.3
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	357	346	11	96.9
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	142	126	16	88.7
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	6	6	-	100.0
Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	18	18	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	156	164	(8)	105.1
Гэрээт ажилтан	6	5	1	83.3
Улс төрийн албан хаагч (УТ)	29	27	2	93.1

2.6 Аудит хийсэн нэгдсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,084,760.5
УРСГАЛ ЗАРДАЛ		1,084,760.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		425,955.5
Хангамж, бараа материалын зардал		1,202.0
Тээвэр, шатахуун		500.0
Ном, хэвлэл		572.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		130.0
Нормативт зардал		1,000.0
Хоол, хүнс		1,000.0
Эд хогшил, урсгал засварын зардал		173,625.0
Багаж, техник, хэрэгсэл		7,000.0
Тавилга		2,125.0
Урсгал засвар		164,500.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		196,483.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		196,483.0
Бараа үйлчилгээний бусад зардал		53,645.5
Бараа үйлчилгээний бусад зардал		53,645.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		658,805.0
Бусад урсгал шилжүүлэг		658,805.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		640,000.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		18,805.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1,084,625.5
Нэмэлт санхүүжилтийн орлого		1,084,625.5
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,084,625.5
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		(135.0)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		(135.0)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн эрхэм зорилго нь “Бүтээлч, оюунлаг, эрүүл иргэнтэй, амар тайван, аюулгүй орчинтой, ногоон хөгжлийг эрхэмлэсэн, үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлсэн, зохистой хөдөлмөрийг дэмжсэн, хариуцлагатай, цахим систем, стандарт бүхий ухаалаг менежментийг хэрэгжүүлсэн, ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БҮХИЙ ДҮҮРЭГ болно” гэж тодорхойлсон байна.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ИТХ-ын 2020 оны 11 дүгээр тогтоолоор Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан. Уг хөтөлбөр нь

- Ковид-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого /6 арга хэмжээ/
- Хүний хөгжлийн бодлого /6 бүлэг, 24 арга хэмжээ/
- Эдийн засгийн бодлого /3 бүлэг, 25 арга хэмжээ/
- Засаглалын бодлого /4 бүлэг, 18 арга хэмжээ/
- Ногоон хөгжлийн бодлого /6 арга хэмжээ/
- Нийслэл ба бус, орон нутгийн хөгжлийн бодлого /6 арга хэмжээ/ -ээс бүрдсэн.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 4 дүгээр сарын 29-нд батлагдсан;
- Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/
- Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөн.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Дотоод аудитын алба нь төлөвлөгөөний дагуу 20 байгууллагын төсвийн төлөвлөлт, төсвийн санхүүжилт, төсвийн зарцуулалт, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа хөрөнгө оруулалт, түүний ашиглалт, үр ашигтай байдал, бүтэц, орон тоо цалин хөлсний тогтоолт, олголт, өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, бүртгэлийн байдалд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийж холбогдох хууль тогтоомж, заавар журмын дагуу илэрсэн зөрчлийг арилгуулах талаар зөвлөмж, албан шаардлага, акт хүргүүлсэн байна. Хяналт шалгалтаар тогтоосон 7,971.3 мянган төгрөгийн төлбөрийн акт барагдаагүй, зөвлөмжийн хэрэгжилт 96.9 хувьтай байна.

Дүүргийн Засаг даргын баталсан удирдамжаар үйл ажиллагаагаа эхэлж байгаа Нийтлэг үйлчилгээний газар, Хайрхан хөгжлийн төв, Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв, Хоймор хайрхан амралт сувиллын газар ОНӨААН-үүдэд Дотоод аудитын алба нийт бүрэлдэхүүнээрээ зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулж, зөвлөмж хүргүүлсэн байна.

Мөн 2022 оны 1 дүгээр 13-ны өдрийн албаны даргын 22/04 дүгээр удирдамжтай 1-19 дүгээр хорооны өрхийн эрүүл мэндийн төвүүд, цэцэрлэгүүд, ерөнхий боловсролын сургуулиуд, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, үнэн зөв байдалд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн 1,444,475.7 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн, хэрэгжилт 82.0 хувьтай байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Дүүргийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн нэгтгэсэн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2021 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн А/371 дүгээр захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг дүүргийн харьяа төсвийн байгууллагууд мөрдөн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, төсвийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 87,795,520.4 мянган төгрөгөөр буюу 41.6 хувиар буурсан байна. Энэ нь өмнөх оны дүүргийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 90 байгууллага /орон нутгийн төсвийн 13 байгууллага, ерөнхий боловсролын 19 сургууль, 37 цэцэрлэг, 16 өрхийн эрүүл мэндийн төв, 5 ОНӨААН/-ын санхүүгийн тайлан нэгтгэгддэг байсан бол 2022 онд дээрх тоо 73-аар буюу 81.1 хувиар буурснаас шалтгаалсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
МӨНГӨН ХӨРӨНГӨ	20,808,124.1	19,388,390.5	(1,419,733.6)
АВЛАГА	362,028.0	279,700.0	(82,328.0)
УРЬДЧИЛГАА	75,414.4	638,558.8	563,144.4
БАРАА МАТЕРИАЛ	8,368,880.5	2,397,392.1	(5,971,488.4)
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10,078,068.6	9,321,313.3	(756,755.3)
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	171,271,995.4	91,144,034.4	(80,127,961.0)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	210,964,511.0	123,169,389.1	(87,795,121.9)
НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,068,989.7	663,871.5	(1,405,118.2)
Засгийн газрын хувь оролцоо	208,895,521.3	122,505,517.6	(86,390,003.7)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	210,964,511.0	123,169,389.1	(87,795,121.9)

Эх сурвалж: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бусад эргэлтийн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцооны данснууд байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 19,388,390.5 мянган төгрөг болж өмнөх оноос 1,419,733.6 мянган төгрөгөөр буюу 6.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	20,411,486.9	16,192,565.8	(4,218,921.1)
Төгрөг	20,411,486.9	16,192,565.8	(4,218,921.1)
Төрийн сангийн харилцах	20,411,128.6	16,192,155.1	(4,218,973.5)
Арилжааны банк дахь харилцах	358.3	410.7	(52.4)
Замд яваа мөнгөн хөрөнгө	396,637.2	3,195,824.7	2,799,187.5
Дүн	20,808,124.1	19,388,390.5	(1,419,733.6)

Эх сурвалж: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн харилцах дансанд 16,192.155.1 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан нь ОНХС-ийн 688,024.6 мянга, дүүргийн хөрөнгө оруулалтын зардлын 427,477.4 мянга, орон нутгийн ерөнхий орлогын дансны 15,076,653.1 мянган төгрөгөөс тус тус бүрдэж байна.

Арилжааны банкны “0” үлдэгдэлтэй төсвийн орлогын харилцах данснаас гүйлгээ хаагдсаны дараа татварын 3,195,824.7 мянган төгрөгийн орлого дүүргийн төрийн сангийн орлогын ерөнхий дансанд 2023 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр он дамжиж орсон тул замд яваа мөнгөн хөрөнгөөр тайлагнажээ.

Аудитын илрүүлэлт:

- Бэлэн мөнгөний тайланг тухай бүр нь гаргаагүй, хагас болон бүтэн жилээр тайлан гаргахдаа орлого, зардлын дүнг арилжааны банкны хуулгаас 7,739.8 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн, нягтлан бодогч хянаагүй. /ЗДТГ/
- Мөнгөн хөрөнгийн данснаас бүрдэл дутуу анхан шатны баримтаар 193,499.5 мянган төгрөгийн гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан. /ЗДТГ 93,321.0 мянга, ИТХ 3,359.8 мянга, ЖДҮДТ 17,555.0 мянга, Тохижилт үйлчилгээний зардал 24,135.0 мянга, Нийгмийн халамж, асрамж үйлчилгээний зардал 10,000.0 мянга, Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨТҮГ 12,800.0 мянга, Хоймор хайрхан ахмадын сувилал ОНӨТҮГ 24,707.5 мянга, Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ 7,621.2 мянган төгрөг/

3.4.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 279,700.0 мянган төгрөг болж өмнөх оноос 82,328.0 мянган төгрөгөөр буюу 22.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	649.8	-	(649.8)
Дансны авлага /ТӨҮГ/	2,500.0	2,500.0	-
Байгууллагаас авах авлага	356,066.7	273,988.4	(82,078.3)
Хувь хүмүүсээс авах авлага	2,811.5	3,211.6	400.1
Дүн	362,028.0	279,700.0	(82,328.0)

Эх сурвалж: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдлийн 96.5 хувь буюу 270,000.0 мянган төгрөг нь Асати Монгол ХХК-иас авах авлага эзэлж байна. Мөн дансны авлага дансанд бүртгэлтэй 2,500.0 мянган төгрөгийн авлага нь Чингэлтэй дүүргийн Ахмадын амралт, сувилал ОНӨУҮГ-тай холбоотой бөгөөд эзэн холбогдогч тодорхойгүй авлага байна. Нийт авлагын 98.8 хувь буюу 276,404.4 мянган төгрөгийн авлага нь он удаан жил болсон авлагууд байна. /Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал 270,668.9 мянга, ИТХ 3,049.4 мянга, Чингэлтэй дүүргийн Ахмадын амралт, сувилал ОНӨУҮГ 2,500.0 мянга, ОНХС 186.0 мянган төгрөг/

Мөн авлагын үлдэгдэлд тооцоо нийлж баталгаажуулаагүй 275,549.4 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байгаа нь нийт авлагын 98.5 хувийг эзэлж байна. /Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал 270,000.0 мянга, ИТХ 3,049.4 мянга, Чингэлтэй дүүргийн Ахмадын амралт сувилал ОНӨААТҮГ 2,500.0 мянган төгрөг /

Аудитын илрүүлэлт:

- Дүүргийн хөрөнгө оруулалтын зардлаас мөсөн гулгуурын талбай бүхий спорт цогцолбор барих ажлын урьдчилгаанд 2011 онд 270,000.0 мянган төгрөг Асати Монгол ХХК-д шилжүүлсэн боловч одоог хүртэл ажил хийгдээгүй байна. Үүссэн авлагыг барагдуулах тухай албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тул дээрх зөрчлийг шалгуулахаар хуулийн байгууллагад шилжүүлсэн. /Дүүргийн ТТЗ/

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 638,558.8 мянган төгрөг болж өмнөх оноос 563,144.4 мянган төгрөгөөр буюу 7.5 дахин өссөн байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	75,414.4	638,558.8	563,144.4
Дүн	75,414.4	638,558.8	563,144.4

Эх сурвалж: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансанд дүүргийн хөрөнгө оруулалтын зардал 614,562.2 мянга, ЗДТГ-ын 23,996.6 мянга, нийт 638,558.8 мянган төгрөгийн урьдчилгаа бүртгэсэн байна. Урьдчилгаа дансны 95.9 хувь буюу 612,562.8 мянган төгрөгийг дүүргийн хөрөнгө оруулалтын зардлаас бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн санхүүжилт эзэлж байна. ЗДТГ-ын урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл өмнөх оноос 51,417.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Дүүргийн хөрөнгө оруулалтын зардлаар иргэд, хүүхэд залуучууд, ахмад настанд зориулсан хөгжлийн төв, спорт заал барих /Баян могод ХХК-д олгосон 552,247.1 мянган төгрөг/, авто замын хөдөлгөөний хяналтын камер суурилуулах /Мөлүү хээр" ХХК-д олгосон 60,315.1 мянган төгрөг/ ажлууд нь гэрээний хугацаа дууссан боловч ажил бүрэн хийгдээгүй байна. /Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал/
- Гадаад томилолтоор ажиллуулах тушаал гаргахдаа ажиллах хугацаа, томилолтоор ажиллах албан тушаалтны нэрсийг зарим тушаалд тусгаагүй, томилолтын удирдамж, хөтөлбөр байхгүй, томилолтоор ажиллах үеийн төсөв батлахдаа унаа, байр, хоолны зардлыг хэрхэн тооцсон нь тодорхойгүй, ажлын тайлан, унааны зардлын баримт зэрэг баримтыг бүрдэлгүй томилолтын урьдчилгааг хаасан. /ЗДТГ/

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 2,397,392.1 мянган төгрөг болж өмнөх оноос 5,971,488.4 мянган төгрөгөөр буюу 71.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	71,796.0	3,589.0	(68,207.0)
Тусгай зориулалттай материал	10,241.7	-	(10,241.7)
Эм боох материал	61,554.3	3,589.0	(57,965.3)
Хангамжийн материал	8,297,084.5	2,393,803.1	(5,903,281.4)
Бичиг хэргийн материал	109,738.8	35,449.4	(74,289.4)
Аж ахуйн материал	427,805.7	166,905.8	(260,899.9)
Сэлбэг хэрэгсэл	28,636.6	16,419.0	(12,217.6)
Түлш, шатах тослох материал	26,954.2	14,096.4	(12,857.8)
Барилгын засварын материал	183,962.8	221,247.5	37,284.7
Хүнсний материал	102,883.4	1,311.6	(101,571.8)
Бусад хангамжийн материал	7,417,103.0	1,938,373.4	(5,478,729.6)
Дүн	8,368,880.5	2,397,392.1	(5,971,488.4)

Эх сурвалж: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бараа материалын данс нь худалдан авсан 2,439,148.9 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 186,210.3 мянга, нийт 2,625,359.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагаанд зарцуулсан 3,142,851.7 мянга, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн улсын төсөвт шилжүүлсэн 5,441,731.7 мянга, байгууллага хооронд шилжүүлсэн 12,264.1 мянга, нийт 8,596,847.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Дүүргийн хөрөнгө оруулалтын зардлаас худалдан авалт хийхдээ tender.gov.mn сайтын цахим дэлгүүрт захиалга өгч, худалдан авалт хийгээгүй, 20.0 сая төгрөгөөс дээших худалдан авалтад үнийн харьцуулалт, судалгаа хийлгүй, шууд худалдан авалт хийсэн.
/Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал/

3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 9,321,313.3 мянган төгрөг болж өмнөх оноос 756,755.2 мянган төгрөгөөр буюу 7.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	10,078,068.5	9,321,313.3	(756,755.2)
Дүн	10,078,068.5	9,321,313.3	(756,755.2)

Эх сурвалж: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Энэхүү дансанд дүүргийн хөрөнгө оруулалтын зардлаар он дамжин хийгдэж байгаа ажлыг урьдчилж төлсөн зардал болон хөрөнгө оруулалтаар хийгдсэн, ашиглагч байгууллага хүлээн аваагүй, холбогдох байгууллагын шийдвэр гараагүй хөрөнгө, тохижилтын ажил бүртгэдэг. Уг дансанд дүүргийн хөрөнгө оруулалтын 9,113,225.6 мянга, ОНХС-ийн 208,087.8 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг бүртгэсэн байна.

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 91,144,034.4 мянган төгрөг болж өмнөх оноос 80,127,961.0 мянган төгрөгөөр буюу 46.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+) Бууралт (-)
Биет хөрөнгө	124,746,871.8	50,228,195.7	(74,518,676.1)
Барилга, байгууламж, орон сууц	111,561,909.6	44,563,738.9	(66,998,170.7)
Авто-тээврийн хэрэгсэл	1,023,152.4	764,809.3	(258,343.1)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	5,379,901.9	2,397,514.4	(2,982,387.5)
Тавилга, аж ахуйн эд хогшил	4,005,568.1	645,027.1	(3,360,541.0)
Бусад үндсэн хөрөнгө	2,266,314.9	1,714,763.5	(551,551.4)
Ном	510,024.9	142,342.5	(367,682.4)
Биет бус хөрөнгө	46,525,123.6	40,915,838.7	(5,609,284.9)
Программ хангамж	58,930.7	17,254.1	(41,676.6)
Бусад биет бус хөрөнгө	46,466,192.9	40,898,584.6	(5,567,608.3)
Дүн	171,271,995.4	91,144,034.4	(80,127,961.0)

Эх сурвалж: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн данс нь төсвийн худалдан авалтаар 739,139.0 мянга, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 5,537,942.8 мянга, нийт 6,277,081.8 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, акталсан 1,429,040.6 мянга, байгууллага хооронд шилжүүлсэн 195,676.0 мянга, нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн улсын төсөвт шилжүүлсэн 98,268,181.1 мянга, нийт 99,892,897.7 мянган төгрөгийн хөрөнгөөр буурсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Чингэлтэй дүүргийн Ахмадын амралт, сувилал ОНӨУҮГ-ын галд шатсан 295,293.2 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хасах ажлыг зохион байгуулаагүй, санхүүгийн тайланд үлдэгдэлтэй дүнгээр тайлагнасан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй. /Дүүргийн ТТЗ/
- Элэгдлээрээ өртгөө нөхсөн, үлдэгдэл өртөггүй хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй. /ЗДТГ 16,291,359.2 мянга, ИТХ 171,836.7 мянга, Хүүхдийн номын өргөө 9,277.8 мянга, ХААА 47,645.7 мянга, ЖДҮДТ 429,564.2 мянган төгрөг/

3.4.7 Өр төлбөр

Өр төлбөр дансны үлдэгдэл 663,871.5 мянган төгрөг болж өмнөх оноос 1,405,118.2 мянган төгрөгөөр буюу 67.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 8. Өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Өглөг	1,969,278.3	519,626.5	(1,449,651.8)
Ажилчидтай холбогдсон өглөг	9,291.9	3,365.1	(5,926.8)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,959,986.4	516,261.4	(1,443,725.0)
Бусад өглөг	99,711.4	144,245.0	44,533.6
Байгууллагад төлөх өглөг	93,574.9	138,314.7	44,739.8
Хувь хүмүүст төлөх өглөг	206.2	-	(206.2)
Татварын өглөг /ТӨҮГ/	2,987.1	2,987.1	-
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	2,943.2	2,943.2	-
Дүн	2,068,989.7	663,871.5	(1,405,118.2)

Эх сурвалж: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 663,871.5 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнаснаас 649,053.1 мянган төгрөг буюу 97.8 хувийг хөрөнгө оруулалтын ажлын барьцаа эзэлж байна. Мөн үйл ажиллагаа явуулаагүй Чингэлтэйн дүүргийн Ахмадын амралт, сувилал ОНӨУҮГ-тай холбоотой 5,930.3 мянган төгрөгийн татвар, НДШ-ийн өглөг тайлагнасан байна. Нийт өр төлбөрийн 7.2 хувь буюу 44,509.0 мянган төгрөгийн үлдэгдэлд тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- 2017-2018 онуудад хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлд заасан барьцааны хугацаа дууссан барьцааг орон нутгийн төсвийн орлогын ерөнхий дансанд төвлөрүүлээгүй. *Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал 36,315.3 мянга, ОНХС 17,739.5 мянган төгрөг/*

3.4.8 Засгийн газрын оролцоо

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 122,505,517.6 мянган төгрөг болж өмнөх оноос 86,390,003.7 мянган төгрөгөөр буюу 41.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	84,663,141.7	62,307,492.3	(22,355,649.4)
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	84,623,141.7	62,267,492.3	(22,355,649.4)
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	40,000.0	40,000.0	-
Хуримтлагдсан үр дүн	85,440,450.3	48,764,318.5	(36,676,131.8)
Өмнөх үеийн үр дүн	65,889,183.7	134,503,792.2	68,614,608.5
Тайлант үеийн үр дүн	19,551,266.6	(85,739,473.7)	(105,290,740.3)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	38,791,929.3	11,433,706.8	(27,358,222.5)
Дүн	208,895,521.3	122,505,517.6	(86,390,003.7)

Эх сурвалж: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтад өөрчлөлт орсноор дүүргийн чиг үүрэгт дүүргийн сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, номын сан, биеийн тамир, спортын цогцолборын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засварыг хариуцах болсонтой холбоотойгоор орон нутгийн төсвөөс сургууль, цэцэрлэгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг улсын төсөвт шилжүүлсэн. Иймд дүүргийн ТТЗ-ийн тайлангийн үр дүн, орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгөд нөлөө бүхий өөрчлөлт гарсан.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Дүүргийн ТТЗ-ийн 2022 оны төсвийн төсөлд дүүргийн орон нутгийн төсвийн байгууллагын урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 170,630,082.4 мянган төгрөгөөр, урсгал зарлагыг 170,630,082.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг дүүргийн ИТХ-аар хэвээр баталсан байна.

3.5.2 Дүүргийн төсвийн орлого бүрдүүлэлт

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ИТХ-ын “Дүүргийн 2022 оны төсөв батлах тухай” 2021 оны 12 дугаар сарын 17-ны 07 дугаар тогтоолоор анх төсвийн орлогыг 158,612,073.0

мянга, өөрийн орлогыг 178,551.1 мянга, урд оны үлдэгдлээс 10,511,121.3 мянга, ОНХС-ийн санхүүжилтийг 1,328,337.0 мянга, нийт 170,630,082.4 мянган төгрөгөөр үүнээс нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлого 101,108,682.4 мянга, төсвийн нийт зарлагыг 69,521,400.0 мянган төгрөгөөр төсвийг ашиг, алдагдалгүй байхаар баталжээ.

Төсөвт нэмэлт өөрчлөлт оруулан дүүргийн ИТХ-ын “Дүүргийн төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2022 оны 15 дугаар тогтоолоор төсвийн орлогыг 155,426,073.0 мянга, өөрийн орлогыг 152,855.6 мянга, урд оны үлдэгдлээс 20,449,157.4 мянга, ОНХС-ийн санхүүжилтийг 1,283,281.4 мянга, нийт 177,311,367.4 мянган төгрөгөөр үүнээс нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлого 101,019,706.5 мянга, төсвийн нийт зарлагыг 76,291,660.9 мянган төгрөгөөр төсвийг ашиг, алдагдалгүй байхаар баталжээ.

Тайлант онд 155,578,928.6 мянган төгрөгийг дүүргийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 159,115,666.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 102.3 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 10. Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	155,578,928.6	159,115,666.2	3,536,737.6	102.3
ТАТВАРЫН ОРЛОГО	153,362,113.2	157,935,712.9	4,573,599.7	103.0
Хувь хүний орлогын албан татвар	113,795,570.6	117,787,303.3	3,991,732.7	103.5
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	73,996,808.7	83,315,923.3	9,319,114.6	112.6
Үйл ажиллагааны орлого	945,542.8	947,606.0	2,063.2	100.2
Хөрөнгийн орлого	26,944,272.6	14,386,301.0	(12,557,971.6)	53.4
Хөрөнгө борлуулсны орлого	1,756,900.0	2,529,618.0	772,718.0	144.0
Шууд бус орлого	10,152,046.5	16,607,855.0	6,455,808.5	163.6
Хөрөнгийн албан татвар	6,312,164.9	4,279,843.0	(2,032,321.9)	67.8
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	6,275,147.8	4,237,406.0	(2,037,741.8)	67.5
Бууны албан татвар	37,017.1	42,437.0	5,419.9	114.6
Бусад татвар, төлбөр, хураамж	33,254,377.7	35,868,566.6	2,614,188.9	107.9
Улсын тэмдэгтийн хураамж	28,286,861.1	32,384,133.6	4,097,272.5	114.5
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,446,055.1	1,750,342.0	304,286.9	121.0
Газрын төлбөр	3,521,461.5	1,672,502.0	(1,848,959.5)	47.5
Ангилалдаагүй бусад орлого	-	61,589.0	61,589.0	
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,216,815.4	1,179,953.3	(1,036,862.1)	53.2
Нийтлэг татварын бус орлого	2,216,815.4	1,179,953.3	(1,036,862.1)	53.2
Торгуулийн орлого	2,063,959.8	979,875.9	(1,084,083.9)	47.5
Төсөв байгууллагын өөрийн орлого	152,855.6	200,077.4	47,221.8	130.9

Төлөвлөгөө тасарсан орлогууд: Торгуулийн орлого 47.5 хувийн, газрын төлбөр 47.5 хувийн, хөрөнгийн орлого 53.4 хувийн, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 67.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Торгуулийн орлого: Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуулийн дагуу нөхөн төлбөрөө төлсөн тохиолдолд өршөөлд хамруулсан, үйл ажиллагаа доголдсон татвар төлөгчдийг татварын хяналт шалгалтад хамруулах нь багассан, эрсдэлээр үнэлж, зөвхөн эрсдэл өндөртэй татвар төлөгчдийг хяналт шалгалтад хамруулах чиглэлийг анхааран ажилласан зэрэг нь хүү, торгуулийн орлогын төлөвлөгөө тасрахад нөлөөлсөн.

Газрын төлбөр: Газрын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь заалтын дагуу Газар зохион байгуулал, геодези, зураг зүйн газар болон Татварын ерөнхий газрын дарга нарын хамтран батлах Мэдээллийг цахим болон бусад хэлбэрээр солилцох журмыг хугацаа хоцорч баталснаас газрын төлбөрийн ногдол үүсэх системийн иж бүрэн ажиллах бэлтгэл

ажлыг оны эхнээс хангуулаагүйтэй холбоотойгоор тайлант хугацаанд ногдох газрын төлбөр, үүссэн өр, дутуу үлдэгдлийг хураан барагдуулах ажил удааширсан.

Хөрөнгийн орлого: Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх заалтад цар тахлын үед банкны хугацаагүй хадгаламж, харилцах дансанд хүү тооцохгүй байхаар зохицуулсантай холбоотой хөрөнгийн орлого тасарсан.

Үл хөдлөх эд хөрөнгийн татвар: 2021 оноос өмнөх өр нийслэлийн төсөвт, 2022 оны ногдол дүүргийн төсөвт төвлөрөхөөр зохицуулалт хийгдсэн боловч 2020 оноос 2022 он хүртэлх хугацаанд Дэлхий нийтээр ковид-19 цар тахал дэгдсэний улмаас иргэдийн амьдралд сөргөөр нөлөөлсөн, тус онуудад үл хөдлөх эд хөрөнгийн өр төлбөр их хэмжээгээр хуримтлагдсан бөгөөд иргэд тухайн онуудад үйл ажиллагаа явуулаагүй тул татвар төлөхгүй гэсэн буруу ойлголттой татварын өрөө төлөөгүй тохиолдлууд их гарсан зэрэг нь үл хөдлөх эд хөрөнгийн татварын орлого тасрахад нөлөөлсөн.

3.5.3 Дүүргийн төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 6,681,285.0 мянга төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Нийслэлийн төсөвт 101,019,706.5 мянган төгрөг төвлөрүүлэхээр, ИТХ 3,508,012.9 мянга, Засаг дарга 43,005,410.1 мянга, хөрөнгө оруулалтын ажилд 29,778,237.9 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

Хүснэгт 11. Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	177,311,367.4	161,869,809.1	15,441,558.3	91.3
УРСГАЛ ЗАРДАЛ	149,530,236.0	146,592,937.6	2,937,298.4	98.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,958,571.1	43,129,365.5	1,829,205.6	95.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,024,245.9	6,665,638.1	358,607.8	94.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	940,403.4	861,332.3	79,071.1	91.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,606,257.9	5,797,676.5	808,581.4	87.8
Хангамж, бараа материалын зардал	12,794,054.0	12,764,509.1	29,544.9	99.8
Нормативт зардал	56,212.2	40,806.9	15,405.3	72.6
Эд хогшил, урсгал засварын зардал	2,487,917.4	2,377,405.0	110,512.4	95.6
Томилолт, зочны зардал	437,000.0	367,513.5	69,486.5	84.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,139,014.4	11,047,633.4	91,381.0	99.2
Бараа үйлчилгээний бусад зардал	3,473,465.9	3,206,850.7	266,615.2	92.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	104,571,664.9	103,463,572.1	1,108,092.8	98.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,781,131.4	15,276,871.5	12,504,259.9	55.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 1,084,625.5 мянган төгрөг орж ирснийг хангамж, бараа материалын зардалд 1,202.0 мянга, нормативт зардалд 1,000.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 173,625.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 196,483.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 53,645.5 мянга,

хэлмэгсдэд олгосон цагаатгалын нөхөн олговорт 640,000.0 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 18,805.0 мянга, нийт 1,084,760.5 мянган төгрөгийг зарцуулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.6.5 Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ИТХ-ын “Дүүргийн 2022 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2022 оны 26 дугаар тогтоолоор он дамжсан 42 төсөл, арга хэмжээний нийт 8,770,568.6 мянга, 2022 онд хэрэгжих 59 төсөл, арга хэмжээний 19,010,562.8 мянга, нийт 27,781,131.4 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийхээр баталжээ.

Хөрөнгө оруулалтын 101 төсөл, арга хэмжээнд 27,781,131.4 мянган төгрөгийн санхүүжилт орж ирснээс, гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд 7,702,496.0 мянга, иргэдэд газрын нөхөн олговорт 10,690,914.8 мянга, барьцаанд 216,852.2 мянга, нийт 18,611,140.5 мянган төгрөгийг олгож, дүүргийн ерөнхий орлогын дансанд 9,169,990.9 мянган төгрөгийг төвлөрүүлж, үлдэгдэлгүй тайлагнасан байна.

ОНХС-гийн хөрөнгө оруулалт:

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ИТХ-ын “Дүүргийн 2022 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2022 оны 26 дугаар тогтоолоор он дамжсан 18 төсөл, арга хэмжээний нийт 708,407.1 мянга, 2022 онд хэрэгжих 18 төсөл, арга хэмжээний 1,288,699.4 мянга, нийт 1,997,106.5 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр нийслэлийн ОНХС-аас 18 төсөл арга хэмжээнд тайлант оны нийслэлийн төсвөөс 1,283,281.4 мянга, урьд оны үлдэгдэл 713,825.1 мянган төгрөгийн орлого орсноос гүйцэтгэгч байгууллагад 1,931,916.0 мянга, ОНХС-ийн дансанд 65,326.1 мянган төгрөгийн барьцаа төвлөрүүлж, 588,288.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан.

Нийт барьцаа хөрөнгө: Дүүргийн барьцаа хөрөнгийн дансны оны эхний үлдэгдэл 476,137.9 мянган төгрөг байснаас 290,926.5 мянган төгрөгийн барьцааг нэмж байршуулж, 239,851.1 мянган төгрөгийн барьцааг чөлөөлж, оны эцэст 527,213.2 мянган төгрөгийн барьцаа хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

3.6.6 ОНӨААН-ийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Чингэлтэй дүүргийн Ахмадын амралт, сувилал ОНӨУҮГ, Чингэлтэйн ахмадын амралт ОНӨААТҮГ, Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨТҮГ, Хайрхан хөгжлийн төв ОНӨТҮГ, Хоймор хайрхан амралт, сувилал ОНӨТҮГ, Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ гэсэн 6 ААН-ийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн. Тайлант онд Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨТҮГ шинээр байгуулагдаж үйл ажиллагаагаа эхлүүлсэн, Чингэлтэй дүүргийн Ахмадын амралт, сувилал ОНӨУҮГ, Чингэлтэйн ахмадын амралт ОНӨААТҮГ үйл ажиллагаа явуулаагүй байна.

2022 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Чингэлтэй дүүргийн Ахмадын амралт, сувилал ОНӨУҮГ, Чингэлтэйн ахмадын амралт ОНӨААТҮГ-ыг тус тус Хоймор хайрхан амралт, сувилал ОНӨТҮГ-тай нэгтгэх Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ИТХ-ын 29 дүгээр тогтоол гарсан боловч тайлант онд хөрөнгийн хөдөлгөөнийг хийгээгүй байна.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ОНӨААН-үүд нь 2022 онд 4,840,178.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардалд 3,484,083.7 мянган төгрөгийг зарцуулж, 1,356,095.1 мянган төгрөгийн ашигтай ажилласан боловч нийт орлогын 2.7 хувийг байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болгосон байна.

Дүүргийн Засаг дарга орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшнийг батлах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэхэд анхаарах нь зүйтэй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, гүйцэтгэсэн ажлын үр дүнг үнэлж, гэрээ дүгнэсэн акт үйлдэж байх, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг холбогдох байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу, үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд холбогдох хууль тогтоомж, зааврыг мөрдөх, өмнөх аудит болон завсрын аудитаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг НТАГ-ын Санхүү-нийцлийн хэлтсийн ахлах аудитор Г.Долгорсүрэн, аудитор Н.Бадамхатан, Ш.Мөнхжаргал, З.Мөнхзаяа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Отгонбаяр, хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг дарга дүүргийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1/482 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 274,797,665.0 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 5,495,953.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

Тус байгууллагын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн өмнөх оноос 26,432,410.5 мянган төгрөгөөр өссөн тул материаллаг байдлын түвшин 528,648.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 204 дүгээр тогтоолын хэрэгжилтийг шалгахад дүүргийн Засаг даргын зөвлөх ажиллуулж төсвөөс цалин олгосон, авто машин хэрэглэхийг хориглосон албан тушаалтан авто машин хэрэглэж шатахуун зарцуулсан, сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулаагүй, цахим дэлгүүрт байршсан тоног төхөөрөмжийг бусад этгээдээс худалдан авсан, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэж, нөөцөлсөн зэрэг зөрчил илэрсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ЗДТГ нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих мэдээллээс орлогын 800,235.5 мянган төгрөгийн 9 гүйлгээ, зардлын 101,915.5 мянган төгрөгийн 33 гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ, 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал 30,000.0 мянган төгрөгийн мэдээлэл байршуулаагүй, ИТХ 61,800.0 мянга, ЖДҮДТ 80,070.5 мянган төгрөгийн мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан, Тохижилт үйлчилгээний зардал дансны орлогын 52 гүйлгээ, зарлагын 60 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨТҮГ 41,625.0 мянга, Хайрхан хөгжлийн төв ОНӨТҮГ 58,333.5 мянга, Хоймор хайрхан ахмадын сувилал ОНӨТҮГ 131,340.0 мянган төгрөгийн мэдээлэл байршуулаагүй.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай зарим талаар нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн төсвийн байгууллагуудын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар 24,349,742.1 мянган төгрөгийн 145 алдаа, зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн. Зөвлөмжийг хэрэгжүүлэхийн тулд дараах зөрчлүүдийг арилгахаар холбогдох байгууллагад санал хүргүүлсэн байна. Үүнд:

- Биетээр байхгүй, нураасан 16,879.5 мянган төгрөгийн өртөгтэй 2 ширхэг барилгыг данс бүртгэлээс хасуулах;
- Өөр байгууллага ашиглаж үйл ажиллагаа явуулж байгаа болон ашиглах боломжгүй 9,977,049.0 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлэх хүсэлтийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүргүүлсэн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,925,975.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 36,381.2 мянган төгрөгийн төлбөрийн акт бүрэн барагдсан, 1,345,095.5 мянган

төгрөгийн 9 албан шаардлагын хэрэгжилт 77.8 хувьтай, 1,544,499.0 мянган төгрөгийн 135 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Санхүүгийн тайланд тусгагдсан авлага, өр төлбөрийн 671,462.3 мянган төгрөгийн үлдэгдэлд тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, ААН-ээс авах олон жилийн насжилттай 270,000.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй албан шаардлагуудыг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	8	36,381.2	8	36,381.2	100.0
Албан шаардлага	9	1,345,095.2	7	403,632.9	77.8
Зөвлөмж	135	1,544,499.0	135	1,544,499.0	100.0
Нийт дүн	152	2,925,975.4	150	1,984,513.1	92.6

Тайлант онд өмнөх аудитаар илэрсэн зөрчлүүдээс дараах зөрчлүүд давтан гарсан байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө, бараа материал зарлагадахдаа бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан;
2. Ажлын гүйцэтгэл үр дүн харгалзаагүй, байгуулсан гэрээг дүгнэлгүйгээр санхүүжилт олгосон;
3. Худалдан авалт болон ажил үйлчилгээний төлбөрийг и-баримтгүй шилжүүлсэн;
4. Авлага, өр төлбөрийн үлдэгдэлд тооцоо нийлж баталгаажуулаагүй;
5. Шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлээгүй, хугацаа хоцроож мэдээлсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараагийн аудитаар анхаарал хандуулах доорх асуудлууд гарсан. Үүнд:

- Бусад эргэлтийн хөрөнгө дансанд дүүргийн хөрөнгө оруулалтын зардлаар он дамжин хийгдэж байгаа ажлыг урьдчилж төлсөн зардал болон хөрөнгө оруулалтаар хийгдсэн, ашиглагч байгууллага хүлээн аваагүй, холбогдох байгууллагын шийдвэр гараагүй хөрөнгө, тохижилтын ажил бүртгэдэг. Хөрөнгө оруулалтаар хийгдэж дууссан ажлуудыг тухай бүр нь холбогдох байгууллагуудад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүйгээс бусад эргэлтийн хөрөнгө дансанд 2018-2021 онуудад хийгдсэн дүүргийн хөрөнгө оруулалтын 9,113,225.6 мянга, ОНХС-ийн 208,087.8 мянган төгрөгийн ажлууд бүртгэлтэй хэвээр байна. Иймд дансны үлдэгдлийг цэгцлэх, Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүсэлт хүргүүлж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах нь зүйтэй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж гаргалаа.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 11 төсвийн байгууллага, сан, зардал, 6 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 17 байгууллага, сан, зардал аудитад хамрагдсан. Үүнд: Орон нутгийн төсвийн 7 байгууллага /ИТХ, ЗДТГ, ЖДҮДТ, ХААА, Дотоод аудитын алба, Хүүхдийн номын өргөө, Соёлын төв/, 4 сан, зардал /Нийгмийн халамж, асрамж үйлчилгээний зардал, Тохжилт үйлчилгээний зардал, ОНХС, Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал/, 6 ОНӨААН /Чингэлтэй дүүргийн Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨТҮГ, Чингэлтэй дүүргийн Ахмадын амралт сувилал ОНӨУҮГ, Чингэлтэйн ахмадын амралт ОНӨААТҮГ, Чингэлтэй дүүргийн Хайрхан хөгжлийн төв ОНӨТҮГ, Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ, Чингэлтэй дүүргийн Хоймор хайрхан амралт, сувилал ОНӨТҮГ/ -ын санхүүгийн тайланг хамруулж, аудитын горим, сорилыг хэрэгжүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	НТАГ-аас дүгнэлт гаргасан	Аудитын хуулийн этгээдээр гэрээгээр хийлгэж дүгнэлт гаргасан	Үе шатны ажлыг хэсэгчлэн хийсэн	Аудитад хамрагдаагүй
1	ТШЗ	2		9	
2	ОНӨААН	1		5	
	Дүн	3		14	

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” /ИТХ, ЗДТГ, Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ/ дүгнэлт өгсөн.

5.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Аудитаар нийт 2,080,932.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Аудитаар нийт 2,937,060.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 82,264.7 мянган төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 951,406.6 мянган төгрөгийн 13 албан шаардлага хүргүүлж, 1,633,389.5 мянган төгрөгийн 51 зөвлөмж өгч 1 зөрчлийг шалгуулахаар хуулийн байгууллагад шилжүүлсэн.

5.1.1 Орон нутгийн байгууллага

Аудитаар нийт 2,127,494.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 82,264.7 мянган төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт, 951,406.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 13 албан шаардлага, 1,093,823.2 мянган төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 30 зөвлөмжийг холбогдох шалгагдагч байгууллагад тус тус хүргүүлсэн.

Төлбөрийн акт

1.Төсвийн хөрөнгөөр кофе чанагч 2,999.9 мянган төгрөгөөр худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.4."багийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төв, хорооны засаг захиргааны зориулалттай барилга барих, тохижуулах, засварлах, тоног төхөөрөмж худалдан авах" заалтуудтай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй. /ИТХ/

2. Албан тушаалын суудлын авто машин ашиглахыг хориглосон Засаг даргын орлогч, зөвлөх, ЗДТГ-ын дарга зэрэг албан тушаалтан албаны авто машин ашиглаж төсвөөс 5,406.7 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 *"Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно"* заалтыг зөрчсөн, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй. /ЗДТГ/

3. Завсрын аудитаар үндсэн хөрөнгийн нэр төрлийг түүвэрлэн биет тест хэрэгжүүлэхэд 12,333.5 мянган төгрөгийн 6 ширхэг зөөврийн компьютер, 7,469.8 мянган төгрөгийн 5 ширхэг iPad дутсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 *"үнэн зөв байх,"* мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* заалтуудыг хэрэгжүүлээгүй, "оршин байх" батламж мэдэгдлийг хангаагүй. /ЗДТГ/

4. 2017-2018 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлд заасан барьцааны хугацаа дууссан 17,739.5 мянган төгрөгийн барьцааг орон нутгийн төсвийн орлогын ерөнхий дансанд төвлөрүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 *"үнэн зөв байх,"* Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 *"Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ"* заалтыг зөрчсөн, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй. /Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал 36,315.3 мянга, ОНХС 17,739.5 мянган төгрөг/

Албан шаардлага

1. Шаардлагагүйгээр 19,255.0 мянган төгрөгийн бараа, материал бэлтгэж нөөцөлсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 *"хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх,"* Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6. *"нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх"* заалтыг зөрчсөн, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй. /ИТХ/

2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс Чингэлтэй дүүргийн Прокурорын газарт 22,959.8 мянган төгрөгийн таблет худалдан авч өгсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах,"* Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 *"Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг энэ хуульд заасны дагуу баталсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу явуулна,"* 8 дугаар зүйлийн 8.2.6 *"төсвийн хөрөнгийг зарцуулах үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах"* заалтыг зөрчсөн, "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна. 1. Засаг дарга зөвлөх чиг үүрэг бүхий албан тушаалтан ажиллуулж төсвөөс 13,087.3 мянган төгрөгийн цалин олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 *"Засгийн газрын агентлагийн дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд ажиллуулахыг хориглоно"* заалтыг зөрчсөн, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй. /ИТХ/

3. Засаг даргын зөвлөх чиг үүрэг бүхий албан тушаалтан ажиллуулж төсвөөс 13,087.3 мянган төгрөгийн цалин олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 *"Засгийн газрын агентлагийн дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн болон орон*

нутгийн өмчит хуулийн этгээдэд зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд ажиллуулахыг хориглоно” заалтыг зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй. /ЗДТГ/

4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулаагүй, төсөв хэмнэх арга хэмжээ аваагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно, 15.2.3 сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” заалтыг зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй. /ЗДТГ/

5. Байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй авто машиныг Засгийн газрын “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2022 оны 204 дүгээр тогтоолын 1. “Автомашин хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа, төрийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт, орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх мэдээллийг аймаг, нийслэлийн Засаг даргад тус тус хүргүүлж, тогтоосон хугацаанд батлагдсан хуваарийн дагуу заасан байршилд татан төвлөрүүлж, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасгай” заалтын дагуу шилжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй. /ЗДТГ/

6. Тайлант хугацаанд цахим и-баримтын дүнгээс бараа материал, ажил үйлчилгээний төлбөрийг илүү шилжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7.“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2.“бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”; 17.6.“Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” заалттай нийцээгүй, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй. /ЗДТГ/

7. Гадаад томилолтоор ажиллуулах тушаал гаргахдаа ажиллах хугацаа, томилолтоор ажиллах албан тушаалтны нэрсийг зарим тушаалд тусгаагүй, томилолтын удирдамж, хөтөлбөр байхгүй, томилолтоор ажиллах үеийн төсөв батлахдаа унаа, байр, хоолны зардлыг хэрхэн тооцсон нь тодорхойгүй, ажлын тайлан, унааны зардлын баримт зэрэг баримтыг бүрдүүлэлгүйгээр томилолтын урьдчилгааг хаасан. Энэ нь Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журмын 2.1 “Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно.”, 2.2 “Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ: 2.2.1. унааны зардал; 2.2.2. байрны зардал; 2.2.3. хоолны зардал.”, 2.10 “Унааны зардлын баримт (онгоц, галт тэрэг, хот хоорондын нийтийн тээврийн тасалбар, автомашин хөлсөлсөн бол ажил гүйцэтгэх гэрээ эсхүл шатахуун худалдан авсан тасалбар)-ыг төрийн албан хаагч албан томилолтын тайландаа хавсаргах ба хоолны болон байрны зардлын баримтыг албан томилолтоор ажилласан төрийн албан хаагчаас шаардахгүй байж болно.” заалттай нийцээгүй, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй. /ЗДТГ/

8. Тайлант онд 5 ажилтны 37,776.9 мянган төгрөгийн нөхөн олговрыг төсвөөс төлсөн, дүүргийн дотоод аудитын алба гэм буруутай албан тушаалтнаар төлүүлэх арга хэмжээ аваагүй нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны

байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ.", 103.3 *"Энэ хуулийн 103.2-т заасан дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж байхгүй бол гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг төрийн аудитын байгууллага хариуцна."* заалттай нийцээгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангаагүй. /ЗДТГ/

9. Санхүүгийн тайланд тусгасан 243,765.4 мянган төгрөгийн авлага, ер төлбөрийн үлдэгдэлд тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* заалттай нийцээгүй, "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангаагүй. /ИТХ 3,049.4 мянга, ЗДТГ 36,012.2 мянга, Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал 149,620.1 мянга, ОНХС 55,083.7 мянган төгрөг/

10. Дүүргийн хөрөнгө оруулалтын зардлаар иргэд, хүүхэд залуучууд, ахмад настанд зориулсан хөгжлийн төв, спорт заал барих */Баян могод ХХК-д олгосон 552,247.1 мянган төгрөг/*, авто замын хөдөлгөөний хяналтын камер суурилуулах */Мөлүү хээр" ХХК-д олгосон 60,315.1 мянган төгрөг/* ажлууд нь гэрээний хугацаа дууссан боловч ажил бүрэн хийгдээгүй байна. /Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал/

5.1.2 Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагууд

Аудитаар нийт 80,172.9 мянган төгрөгийн зөрчил илэрснийг давтан гаргахгүй байх 16 зөвлөмжийг холбогдох шалгагдагч байгууллагад тус тус хүргүүлсэн.

5.2 ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Аудитаар нийт 181,085.8 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын залруулсан. Аудитаар нийт 729,393.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 270,000.0 мянган төгрөгийн зөрчлийг шалгуулахаар хуулийн байгууллагад шилжүүлж, 459,393.4 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгсөн.

Дүүргийн хөрөнгө оруулалтын зардлаас мөсөн гулгуурын талбай бүхий спорт цогцолбор барих ажлын урьдчилгаанд 2011 онд 270,000.0 мянган төгрөг Асати Монгол ХХК-д шилжүүлсэн боловч одоог хүртэл ажил хийгдээгүй байна. Үүссэн авлагыг барагдуулах тухай албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тул дээрх зөрчлийг шалгуулахаар хуулийн байгууллагад шилжүүлсэн. /Дүүргийн ТТЗ/

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

- Дүүргийн ОНӨААТҮГ-ууд нь 2021 оны санхүүгийн тайланд 201,241.2 мянган төгрөгийн цэвэр ашиг тайлагнасан боловч 2022 оны дүүргийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хувь хэмжээг ИТХ-аар тогтоолгож, орлогыг нэмэгдүүлж төлөвлөөгүй байна.
- Дүүргийн 2022 оны төсөв батлах тухай тогтоолд өмнөх онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж дуусан 75,543.6 мянган төгрөгийн ажлыг 2022 оны дүүргийн төсөвт дахин оруулж баталсан.
- ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлыг батлахдаа 44,938.6 мянган төгрөгийн төсөл арга хэмжээг багц дүнгээр баталсан.

1.2 Өгсөн зөвлөмж:

- Дүүргийн төсвийг үндэслэлтэй төлөвлөх, төсвийн төсөл боловсруулахдаа хариуцлагатай хандах
- Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгаж байх

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

- Дүүргийн ЗДТГ нь ААН-тэй бараа, ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан боловч үр дүнг үнэлж, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, ажлын гүйцэтгэл, үр дүнг тооцолгүйгээр санхүүжилт бүрэн олгосон, бүрдэл дутуу анхан шатны баримтаар гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан /ЗДТГ 93,321.0 мянга, ИТХ 3,359.8 мянга, ЖДҮДТ 17,555.0 мянга, Тохижилт үйлчилгээний зардал 24,135.0 мянга, Нийгмийн халамж, асрамж үйлчилгээний зардал 10,000.0 мянга, Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨТҮГ 12,800.0 мянга, Хоймор хайрхан ахмадын сувилал ОНӨТҮГ 24,707.5 мянга, Нийтлэг үйлчилгээний газар 7,621.2 мянган төгрөг/, тайлант хугацаанд цахим и-баримтын дүнгээс бараа материал, ажил үйлчилгээний төлбөрийг илүү шилжүүлсэн. /ЗДТГ, ИТХ 4,378.2 мянга, Тохижилт үйлчилгээний зардал 32,900.0 мянга, Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал 153,320.9 мянга, Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨТҮГ 3,120.0 мянга, Хайрхан хөгжлийн төв ОНӨТҮГ 1,490.5 мянга, Хоймор хайрхан ахмадын сувилал ОНӨТҮГ 11,441.9 мянган төгрөг/
- Дүүргийн хөрөнгө оруулалтын зардлаас 389,646.4 мянган төгрөгийн зураг төслийн ажлуудыг бараа материалын нөөцөд бүртгээгүй, шууд зардлаар бүртгэсэн, ЗДТГ 39,000.0 мянган төгрөгийн гадаад томилолт болон хөрөнгө оруулалтын зардлыг бусад зардлаас зарцуулсан.
- Цахим дэлгүүрт байршсан 8,962.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг бусад этгээдээс худалдан авсан /ЖДҮДТ/, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлээгүй, шууд гэрээ байгуулж, худалдан авалт хийсэн. /ЗДТГ, Нийтлэг үйлчилгээний газар/
- Тайлант онд дүүргийн ИТХ нь төсвийн хөрөнгөөр хийгдсэн 2,520.0 мянган төгрөгийн видео шторк, контентыг зардлаар бүртгэсэн нь Зар сурталчилгааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 "Зар сурталчилгаа захиалагч, бүтээгч, түгээгч зар сурталчилгаатай холбоотой баримт болон тэдгээрийн хуулбарыг тухайн зар сурталчилгааг сүүлчийн удаа түгээснээс хойш 6 сараас доошгүй хугацаагаар хадгална" заалтыг зөрчсөн.
- Нийгмийн халамж, асрамж үйлчилгээний зардлаас 20,000.0 мянган төгрөгийг шагнал урамшуулалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх"; 5.1.5 "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.6.6 "тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх" заалтуудыг зөрчсөн.
- Дүүргийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын захиалагчийн болон техник хяналтын зардал, зураг төслийн зардлуудыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн. /Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал 56,059.0 мянга, ОНХС 47,661.0 мянган төгрөг/ Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.5 "барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах", 41 дүгээр зүйлийн 41.2.3 "барилгын ажлын талбайд аюулгүй байдлыг хангах зорилгоор захиалагч байнгын хяналт тавьж, шалгалт хийх" заалтуудыг зөрчсөн.
- Ажлын чиг үүрэг давхардсан албан хаагчид 9,707.4 мянган төгрөгийн цалин олгосон. /Хүүхдийн номын өргөө/

- Санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгийн элэгдлийг 11,284.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан. /Нийтлэг үйлчилгээний газар/
- Шатахуун зарцуулалтыг батлагдсан маршрутгүй, жолоочийн тооцоог бодож баталгаажуулаагүй тайланд тусгасан. /Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨТҮГ 2,063.6 мянга, Хайрхан хөгжлийн төв ОНӨТҮГ 2,400.0 мянга, Нийтлэг үйлчилгээний газар 1,840.1 мянган төгрөг/

2.2 Өгсөн зөвлөмж:

- Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар ажил гүйлгээ хийхгүй байх
- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах
- Санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнах
- Шатахууны зарцуулалтыг батлагдсан нормыг үндэслэн тооцоолж санхүүгийн тайланд тусгаж байх
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

3. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

- Бэлэн мөнгөний тайланг тухай бүр нь гаргаагүй, хагас болон бүтэн жилээр тайлан гаргахдаа орлого, зардлын дүнг арилжааны банкны хуулгаас 7,739.8 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн, нягтлан бодогч хянаагүй. /ЗДТГ/

3.2 Өгсөн зөвлөмж:

- Бэлэн мөнгөний зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, бэлэн мөнгөний тайланг тухай бүр нь үнэн зөв гаргаж хэвших

4. Бараа материалын данстай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

- Тайлант оны жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор бараа материал дансны тооцоо бодсон акт байхгүй, агуулахын бүртгэлийн дэвтэр хөтөлдөггүй, хөрөнгийг тоолж эзэмшигчид хүлээлгэн өгсөн карт үйлдээгүй. /Хоймор хайрхан ахмадын сувилал ОНӨТҮГ/
- Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 127,038.9 мянган төгрөгийн худалдан авалт хийхдээ tender.gov.mn сайтын цахим дэлгүүрт захиалга өгч, худалдан авалт хийгээгүй, 20 сая төгрөгөөс дээших худалдан авалтад үнийн харьцуулалт, судалгаа хийлгүй, шууд худалдан авалт хийсэн. /Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал/
- Шатахууныг 100 км-т зарцуулах норм нормативаар тооцолгүйгээр 1,580.0 мянган төгрөгийн шатахууныг зардалд бүртгэсэн. /ХААА/
- Хөрөнгийн үлдэгдлээс түүвэрлэн шалгахад 1,403.8 мянган төгрөгийн бараа материалыг ангилал буруу бүртгэсэн. /Хайрхан хөгжлийн төв ОНӨТҮГ/

4.2 Зөвлөмж:

- Бараа материалын үлдэгдэлд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах
- Шатахуун зарцуулалтыг батлагдсан норм нормативыг үндэслэн тооцох, үр дүнг санхүүгийн тайланд тусгах

5. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт:

- Элэгдлээрээ өртгөө нөхсөн, үлдэгдэл өртөггүй хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй. /төсвийн байгууллагууд/
- Холбогдох байгууллагын шийдвэргүйгээр Чингэлтэйн дүүргийн Ахмадын амралт, сувилал ОНӨУҮГ-т бүртгэлтэй 53,790.0 мянга, Чингэлтэйн Ахмадын амралт ОНӨААТҮГ-т бүртгэлтэй 25,000.0 мянга, нийт 78,790.0 мянган төгрөгийн үнэтэй тээврийн хэрэгслийг бусад байгууллагад шилжүүлэн ашиглуулсан.

- Галд шатсан 295,293.2 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хасах ажлыг зохион байгуулаагүй, санхүүгийн тайланд үлдэгдэлтэй дүнгээр тайлагнасан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй. /Дүүргийн ТТЗ/
- Чингэлтэйн Ахмадын амралт ОНӨААТҮГ-ын дансанд бүртгэлтэй 9,766.6 мянган төгрөгийн хөрөнгийг холбогдох албан тушаалтны шийдвэргүйгээр өөр байгууллагад хөрөнгө ашиглуулсан. /Дүүргийн ТТЗ/
- ЖДҮДТ-ийн барилгыг данс бүртгэлд тусгаагүй, барилгын хувийн хэрэг хөтлөөгүй, тайлант онд НӨХГ-т албан хүсэлт гаргаагүй.
- Эд хөрөнгийн тооллого хийгээд үр дүнг өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцээгүй, ашиглах боломжгүй болон эвдэрсэн хөрөнгийн жагсаалт гаргаагүй, тооллогоор илэрсэн хөрөнгийг НББ-д бүртгээгүй, нягтлан бодогч тооцоо бодсон акт үйлдээгүй. /ЗДТГ/
- Барилга байгууламж, газар, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил зэрэг хөрөнгийг ашиглагч байгууллагын данс бүртгэлд тусгаагүй, холбогдох байгууллагад хүсэлт хүргүүлж, шийдвэрлүүлээгүй. /Хайрхан хөгжлийн төв ОНӨТҮГ, Хоймор хайрхан ахмадын сувилал ОНӨТҮГ/
- Байгууллагын дансанд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг жилийн эцсийн хөрөнгийн тооллогын бүртгэлд хамруулаагүй. /Нийтлэг үйлчилгээний газар/

5.2 Өгсөн зөвлөмж:

- Хөрөнгийн тооллогыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх, үр дүнг санхүүгийн тайланд тусгах, тооллогоор дутсан, байхгүй хөрөнгийг шийдвэрлэх
- Элэгдлээрээ өртгөө нөхсөн, үлдэгдэл өртөггүй хөрөнгийг дахин үнэлэх
- Эд хөрөнгийн хөдөлгөөн хийхдээ Нийслэлийн ИТХ-ын 2014 оны 66 тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ыг мөрдөж ажиллаж бай

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 25 - ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Чингэлтэй дүүргийн ТТЗ	2	181,085.8			2	181,085.8	2	181,085.8				
Чингэлтэй дүүргийн ИТХ	2	12,433.8			2	12,433.8	2	12,433.8				
Чингэлтэй дүүргийн ЗДТГ	5	627,431.7			5	627,431.7	5	627,431.7				
Чингэлтэй дүүргийн ЖДҮДТ	2	27,176.5			2	27,176.5	2	27,176.5				
Чингэлтэй дүүргийн ХААА												
Чингэлтэй дүүргийн Дотоод аудитын алба												
Чингэлтэй дүүргийн Хүүхдийн номын өргөө	2	65,379.6			2	65,379.6	2	65,379.6				
Чингэлтэй дүүргийн Соёлын төв												
Чингэлтэй дүүргийн Нийгмийн халамж, асрамж үйлчилгээний зардал												
Чингэлтэй дүүрэг Тохижилт үйлчилгээний зардал												
Чингэлтэй дүүргийн Орон нутгийн хөгжлийн сан	1	3,888.7			1	3,888.7	1	3,888.7				
Чингэлтэй дүүргийн Хөрөнгө оруулалтын зардал	1	678,556.9			1	678,556.9	1	678,556.9				
Орон нутгийн төсвийн байгууллагуудын дүн	13	1,414,867.2			13	1,414,867.2	13	1,414,867.2				
Чингэлтэй дүүргийн Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв	1	32,045.1			1	32,045.1	1	32,045.1				
Чингэлтэй дүүргийн Хайрхан хөгжлийн төв	1	82,284.2			1	82,284.2	1	82,284.2				
Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар	3	328,175.5			3	328,175.5	3	328,175.5				
Чингэлтэй дүүргийн Хоймор хайрхан амралт, сувилал	2	42,475.1			2	42,475.1	2	42,475.1				
ОНӨААН-ийн дүн	7	484,979.9			7	484,979.9	7	484,979.9				
НИЙТ ДҮН	22	2,080,932.9			22	2,080,932.9	22	2,080,932.9				

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Чингэлтэй дүүргийн ТТЗ	6	729,393.4					5	459,393.4			1	270,000.0
Чингэлтэй дүүргийн ИТХ	7	58,522.1	1	2,999.9	3	45,264.2	3	10,258.0				
Чингэлтэй дүүргийн ЗДТГ	16	252,147.2	2	25,210.0	7	86,876.4	7	140,060.8				
Чингэлтэй дүүргийн ЖДҮДТ	3	26,517.2					3	26,517.2				
Чингэлтэй дүүргийн ХААА	2	1,580.0					2	1,580.0				
Чингэлтэй дүүргийн Дотоод аудитын алба	-	-										
Чингэлтэй дүүргийн Хүүхдийн номын өргөө	2	9,707.4					2	9,707.4				
Чингэлтэй дүүргийн Соёлын төв	-	-										
Чингэлтэй дүүргийн Нийгмийн халамж, асрамж үйлчилгээний зардал	2	30,000.0					2	30,000.0				
Чингэлтэй дүүрэг Тохижилт үйлчилгээний зардал	2	57,035.0					2	57,035.0				
Чингэлтэй дүүргийн Орон нутгийн хөгжлийн сан	4	165,422.8	1	17,739.5	1	55,083.7	2	92,599.6				
Чингэлтэй дүүргийн Хөрөнгө оруулалтын зардал	10	1,526,562.8	1	36,315.3	2	764,182.3	7	726,065.2				
Орон нутгийн төсвийн байгууллагуудын дүн	48	2,127,494.5	5	82,264.7	13	951,406.6	30	1,093,823.2				
Чингэлтэй дүүргийн Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв	3	17,983.6					3	17,983.6				
Чингэлтэй дүүргийн Хайрхан хөгжлийн төв	4	5,294.3					4	5,294.3				
Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар	6	20,745.6					6	20,745.6				
Чингэлтэй дүүргийн Хоймор хайрхан амралт, сувилал	3	36,149.4					3	36,149.4				
ОНӨААН-ийн дүн	16	80,172.9					16	80,172.9				
НИЙТ ДҮН	70	2,937,060.8	5	82,264.7	13	951,406.6	51	1,633,389.5			1	270,000.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Чингэлтэй дүүргийн ИТХ	1	61,800.0					1	61,800.0
Чингэлтэй дүүргийн ЗДТГ	1	902,151.0			1	902,151.0		
Чингэлтэй дүүргийн ЖДҮДТ	1	80,070.5					1	80,070.5
Чингэлтэй дүүрэг Тохижилт үйлчилгээний зардал	1	-					1	
Чингэлтэй дүүргийн Хөрөнгө оруулалтын зардал	1	30,000.0					1	30,000.0
Орон нутгийн төсвийн байгууллагын дүн	5	1,074,021.5			1	902,151.0	4	171,870.5
Чингэлтэй дүүргийн Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв	1	41,625.0					1	41,625.0
Чингэлтэй дүүргийн Хайрхан хөгжлийн төв	1	58,333.5					1	58,333.5
Чингэлтэй дүүргийн Хоймор хайрхан амралт, сувилал	1	131,340.0					1	131,340.0
ОНӨААНБ-ын дүн	3	231,298.5					3	231,298.5
НИЙТ ДҮН	8	1,305,320.0			1	902,151.0	7	403,169.0